



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 630.6 (зургаан зуун гучин сая зургаан зуун) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлт 70.4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул албан даалгаврын биелэлтийг ханган ажиллахыг, “Дархан АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Баясгалан)-д үүрэг болгосугай.

2.“Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

3.1.Компанийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй, батлагдсан зардлын төлөвлөгөөнд тусгаагүй, Төлөөлөн удирдах зөвлөлөөс зөвшөөрч баталгаажуулаагүй, хууль, Контрактын гэрээ (хуучин нэрээр)-нд заагаагүй ажил гүйлгээг дур мэдэн хийх замаар өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан 10.26 сая төгрөгийн хохирлыг Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2021 оны 01/ХТ/2021/00169 дүгээр тогтоолоор компанийн хөрөнгөөр төлж барагдуулсан “Дархан АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Баясгалангаар дээрх төлбөрийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан төлүүлж компанийн дансанд нөхөн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.6.3, 3.6.9, 3.7, 3.8 дахь хэсэг, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 4.2 дахь хэсэгт заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн гүйцэтгэх захирал Б.Баясгаланд хууль тогтоомжийн дагуу хариуцлагын арга хэмжээ авах;

3.3.Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах.

3.4.“Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах;

4. “Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (Б.Баясгалан)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, дотоод хяналтыг сайжруулан, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

4.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх;

4.2. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 8 дугаар тогтоолын 2.2 дугаар дахь хэсэгт “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх.” гэж заасныг мөрдөж ажиллах;

4.3. Компанийн мөнгөн урсгалыг оновчтой төлөвлөх, удирдах, үйл ажиллагааны онцлогтоо тохируулан улирлын шинжтэй мөнгөн хөрөнгийн нөөц бүрдүүлэхэд анхаарч ажиллах, өндөр хүүтэй зээлийн эх үүсвэрээс зайлсхийх, зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авах;

4.4. “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас хүлээлгэн өгсөн үнэ, үнэлгээ тодорхойгүй, цас цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг технологийн зориулалттай тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үнэлж бүртгэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

4.5. Компанийн бараа материалын дансанд бүртгэлтэй 17 нэр төрлийн 8.2 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх саналыг болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, саналыг боловсруулан Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.6. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх, үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

5. Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

6. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтэд Төрийн өмчийн, удирдлага зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т хяналт тавьж ажиллахыг тус тус даалгасугай.

7.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Ц.Түвшинзаяа



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2023 оны 02 дугаар сарын 02-ний  
өдрийн 33 дугаар тогтоолын хавсралт

“Дархан АЗЗА” төрийн өмчит компанид хийсэн  
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах  
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн.	3.3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд хувьцаа эзэмшигчийн хөрөнгийг захиран зарцуулах.
2	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн.	8.2	
3	Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ хийсэн.	52.32	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ хийхийг таслан зогсоох.
4	Компанийн гүйцэтгэх захирал нь контрактын гэрээгээр /хуучин нэрээр/ олгосон эрхээс давуулан шийдвэр гаргасны улмаас төрийн өмчит хувьцаат компанид хохирол учирсан.	10.26	Төсвийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах, ажиллах.
5	Дээд байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлсэн.	7.06	Засгийн газрын 2018 оны "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай" 8 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
6	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан.	374.46	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах.
7	Компанийн мөнгөн хөрөнгийн нөөц бүрдүүлэх зорилгоор иргэнээс зээл авсан.	175.0	Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах, ажиллах.
<b>НИЙТ ДҮН:</b>		<b>630.6</b>	<b>/Зургаан зуун гучин сая зургаан зуун мянга/</b>